



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 44 (329)

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ:

- *Рашааны тухай*
- *Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай*
- *Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот

2003 он



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот

2003 оны арваннэгдүгээр сарын 26

№ 44 (329)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

565.	Рашааны тухай (2003-11-7-ны хууль)	949
566.	Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай (2003-11-7-ны хууль)	953
567.	Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай (2003-11-7-ны хууль)	953
568.	Цагдаагийн байгууллагын тухай хуулийн зарим хэсгийг хүчингүй болсонд тооцох тухай (2003-11-7-ны хууль)	957
569.	"Эрүүл мэндийн салбарын хөгжил-II" төслийн зээлийн гэрээг соёрхон батлах тухай (2003-11-7-ны хууль)	957
570.	"Удаан задардаг органик бохирдуулагчийн тухай конвенци"-д нэгдэн орсныг соёрхон батлах тухай (2003-11-7-ны хууль)	958

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

571.	Газар зүйн нэрийн жагсаалт батлах тухай	Дугаар 42	958
572.	Тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл буцаах тухай	Дугаар 46	958

Гурав. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

573.	Төрийн шагнал хүртээх тухай	Дугаар 173	959
574.	Дүрэм батлах тухай	Дугаар 174	959
575.	Д. Улааныг шүүгчийн албан тушаалаас огцруулах тухай	Дугаар 175	966

Дөрөв. МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

576.	Эрүүгийн хуулийн 175 дугаар зүйлийг тайлбарлах тухай	Дугаар 24	966
------	--	-----------	-----

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2003 оны 11 дүгээр сарын 7-ны өдөр

Улаанбаатар хот

РАШААНЫ ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

2 дугаар зүйл. Рашааны тухай хууль тогтоомж

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь Монгол улсын нутаг дэвсгэрт рашааныг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2.1. Рашааны тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёо

3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:



3.1.1. "рашаан" гэж өвчнийг сэргийлэх, эмчлэх зорилгоор ашиглах, чанар, нөөц нь тодорхойлогдсон рашаан ус, эрдэст нуур, эмчилгээний шавар зэргийг;

3.1.2. "рашааны орд" гэж газрын гадарга, түүний хэвлийд бүрэлдэн тогтсон рашаан ус, эрдэст нуур, эмчилгээний шавар зэрэг байгалийн эмчилгээний хүчин зүйл агуулагдаж байгаа газрыг;

3.1.3. "ариун цэврийн болон хамгаалалтын бүс" гэж рашаан ордыг бохирдох, хомсдохоос хамгаалсан дэглэм тогтоосон талбайг;

3.1.4. "эмчилгээ-сувилгааны зориулалт" гэж өвчнийг эмчлэх, сэргийлэх зорилгоор рашааныг тусгай горимоор хэрэглүүлэхийг;

3.1.5. "үйлдвэрлэл-үйлчилгээний зориулалт" гэж рашааныг ахуйн хэрэгцээнд болон үйлдвэрлэл, үйлчилгээний бусад чиглэлээр ашиглахыг.

4 дүгээр зүйл. Рашааны эрэл хайгуул, түүний санхүүжилт

4.1. Рашааны эрэл хайгуул, судалгааны ажлыг улсын төсвөөр санхүүжүүлнэ.

4.2. Тухайн газрыг эзэмших зөвшөөрөлтэй иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нутаг дэвсгэртээ байгаа рашааны эрэл хайгуул, судалгааны ажлыг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлж болно.

4.3. Эрэл хайгуулын үед илэрсэн рашааны талаархи мэдээллийг улсын нөөцөд бүртгүүлэх ажлыг хайгуул, судалгаа хийсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хариуцна.

5 дугаар зүйл. Рашааны тухай мэдээллийн сан

5.1. Рашааны тухай мэдээллийн сан нь рашаан, эрдэст нуур, эмчилгээний шаврын бүртгэл, нөөц, чанар, найрлага, тэдгээрийн өөрчлөлт, ашиглахтай холбогдсон зураглал, ажиглалт, судалгааны тайлан, мэдээ, мэдээллээс бүрдэнэ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Рашааныг хамгаалах, ашиглах талаархи төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагын бүрэн эрх

6 дугаар зүйл. Төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

6.1. Эрүүл мэндийн болон Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь рашааныг судлах, зохистой ашиглах, хамгаалах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

6.1.1. рашааныг судлах, ашиглах, хамгаалах хөтөлбөрийг боловсруулах;

6.1.2. рашааны стандартыг батлуулах;

6.1.3. рашааны ордыг паспортжуулах;

6.1.4. рашааны эмчилгээний чанарыг тогтоож баталгаажуулах;

6.1.5. рашааныг судлах, ашиглах хүрээнд олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх;

6.1.6. улсын нөөцөд бүртгэгдсэн рашааныг эмчилгээ-сувилгаа, үйлдвэрлэл-үйлчилгээний зориулалтаар хэрэглэх талаар дүгнэлт гаргах;

6.1.7. рашааны тухай мэдээллийн сан бүрдүүлэх;

6.1.8. рашааныг зохистой ашиглах, хамгаалах журам батлах, сурталчлах.

7 дугаар зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрх

7.1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь рашааныг хамгаалах, зохистой ашиглах талаар харьяалах нутаг дэвсгэртээ дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

7.1.1. нутаг дэвсгэртээ байгаа рашааныг зохистой ашиглах, чанарыг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө, түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн хэмжээг батлах;

7.1.2. Монгол Улсын болон гадаадын иргэн, харьяалалгүй хүн, аж ахуйн нэгж, байгууллагад рашааныг гэрээгээр ашиглуулах тухай шийдвэр гаргах.

8 дугаар зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрх

8.1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нь рашааныг хамгаалах, зохистой ашиглах талаар харьяалах нутаг дэвсгэртээ дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

8.1.1. нутаг дэвсгэртээ рашааныг зохистой ашиглах, чанарыг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө, түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн хэмжээг батлуулах;

8.1.2. рашааны хамгаалалтын болон ариун цэврийн дараахь бүсийг холбогдох

мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн тогтоох;

8.1.2.а/ рашааны орд, эх булгийн эргэн тойронд 100 метрт ариун цэврийн бүсийг;

8.1.2.б/ хориглолтын болон хязгаарлалтын бүсээс тогтсон хамгаалалтын бүсийг;

8.1.2.в/ ариун цэврийн бүсийн эргэн тойронд 200 метрээс доошгүй зайд хориглолтын бүсийг;

8.1.2.г/ хязгаарлалтын бүсийг тухайн рашааны ордон нөөц болон геологийн тогтцын онцлог байдлыг харгалзан мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн тогтоох.

8.1.3. эмчилгээний стандартад нийцсэн рашааныг хэрэглэх нөхцөлөөр хангахад дэмжлэг үзүүлэх;

8.1.4. рашааныг нөхөн сэргээх, эх булгийг тохижуулах арга хэмжээ авах;

8.1.5. Монгол Улсын болон гадаадын иргэн, харьяалалгүй хүн /цаашид "иргэн" гэх / аж ахуйн нэгж, байгууллагад рашааныг ашиглуулах гэрээ байгуулж, биелэлтэд хяналт тавих.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Рашааныг хамгаалах.

9 дүгээр зүйл. Рашааныг хомсдох, бохирдохоос хамгаалах

9.1. Хязгаарлалтын бүсэд дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

9.1.1. тухайн рашааны орд газрын байгалийн баялгийг аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын зөвшөөрөлгүйгээр ашиглах;

9.1.2. рашааныг ашиглахтай шууд холбоогүйгээр барилга байгууламж барих;

9.1.3. хог хаягдлын болон бохир ус зайлуулах байгууламж, цэг байрлуулах;

9.1.4. нефтийн бүтээгдэхүүн, химийн хорт бодис, бусад бохирдуулах зүйлсийг ил задгай хаях, хадгалах;

9.1.5. байгальд сөрөг нөлөөлөл үзүүлэх үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах.

9.2. Хориглолтын бүсэд дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

9.2.1. газрын хөрс, ургамлыг гэмтээх, агаарыг бохирдуулах;

9.2.2. газар тариалан эрхлэх, хадлан өвс бэлтгэх, мал бэлчээрлүүлэх;

9.2.3. ахуйн бохир хуурай хог хаях, хадгалах, бохир усыг ил задгай асгах, бохирын цооног байгуулах;

9.2.4. рашааныг ашиглах зориулалттай барилга байгууламжийг бохир ус зайлуулах байгууламжгүй барих.

9.3. Ариун цэврийн бүсэд дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

9.3.1. элдэв металл, хог болох бусад зүйлсийг рашаан усанд хаях;

9.3.2. рашаан авч ашиглахаас өөр зориулалтаар барилга байгууламж барих, тоног төхөөрөмж суурилуулах;

9.3.3. аливаа бохирдол үүсгэх, эм урвалж болон химийн бодисыг хаях, хадгалах.

9.4. Рашааныг ашиглагч нь холбогдох хууль тогтоомж, технологийн горим зөрчсөнөөс рашааны орд, ундарга, нөөц хомсдож, чанар нь алдагдвал иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийг үндэслэн аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга ашиглалтыг зогсоож, нөхөн сэргээх ажлыг гэм буруутай иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын зардлаар гүйцэтгүүлнэ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Рашаан ашиглах

10 дугаар зүйл. Рашааныг ашиглах зориулалт

10.1. Рашааныг дараахь зориулалтаар ашиглана:

10.1.1. эмчилгээ-сувилгааны;

10.1.2. үйлдвэрлэл-үйлчилгээний.

11 дүгээр зүйл. Рашааныг ашиглах тухай хүсэлт гаргах, гэрээ байгуулах

11.1. Рашааныг ашиглах тухай иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийг аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал шийдвэрлэнэ.

11.2. Рашаан ашиглахыг хүссэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллага дараахь баримт бичгийг бүрдүүлнэ:

11.2.1. нөөцийг бүртгүүлсэн баримт;



11.2.2. рашааныг ашиглах, хамгаалах төсөл;

11.2.3. эрүүл мэнд болон байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дүгнэлт;

11.2.4. рашааныг ашиглах, хамгаалах төсөлд хийсэн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр;

11.2.5. рашааны хамгаалалтын болон ариун цэврийн бүс тогтоох тухай санал;

11.2.6. рашааныг савлах, халаалт, эрчим хүчний эх үүсвэрт ашиглах бол Улсын мэргэжлийн хяналтын байгууллагын дүгнэлт.

11.3. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад рашаан ашиглуулах тухай гэрээг Эрүүл мэндийн болон Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрээр баталсан журмын дагуу байгуулна.

11.4. Нэг ордыг хэд хэдэн этгээд шинээр ашиглах хүсэлт гаргавал сонгон шалгаруулалт / тендер / -ын журмаар шийдвэрлэнэ.

11.5. Хэрэв хамтран ашиглах бол Засгийн газраас баталсан тусгай журмаар зохицуулна.

11.6. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага рашааныг хэсэгчлэн ашиглах хүсэлт гаргавал анхны гэрээгээр ашиглагчийн саналыг авч, тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал шийдвэрлэнэ.

11.7. Рашаан ашиглуулах гэрээний хугацааг Засгийн газраас тогтооно.

12 дугаар зүйл. Рашаан ашиглах зөвшөөрөл олгох

12.1. Рашаан ашиглах зөвшөөрөл олгох асуудлыг Усны тухай болон Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд заасан журмын дагуу шийдвэрлэнэ.

13 дугаар зүйл. Рашаан ашиглахад тавих шаардлага

13.1. Рашаан ашиглах иргэн, аж ахуйн нэгж, байгууллага дараахь шаардлагыг биелүүлнэ:

13.1.1. рашаан, эрдэст нуур, эмчилгээний шаврын найрлага, чанарын үнэлгээний үзүүлэлтэд горимын ажиглалт хийлгэн баталгаажуулж, хэрэглэгчдэд ил тод мэдээлж байх;

13.1.2. рашаан ашиглах нөхцөл, технологийн шаардлагын дагуу үйлдвэрлэл, үйлчилгээгээс гарах хаягдал рашааныг цэвэршүүлэх байгууламж барьж ашиглах буюу зайлуулах цэг тогтоолгох;

13.1.3. газрын хөрсийг намагших, эвдрэхэд хүргэхээр барилга байгууламж, далан, суваг, цөөрөм зэргийг байгуулж ашиглахгүй байх;

13.1.4. жил бүр байгаль орчныг хамгаалах талаар хийсэн ажлаа тайлагнаж, ирэх оны төлөвлөгөөг хянуулах;

13.1.5. рашааны ордыг бохирдолт, хомсдолтоос хамгаалах зорилгоор ариун цэврийн болон хамгаалалтын бүсийн хил, заагийг мэдэгдэхүйцээр тэмдэгжүүлэх.

14 дүгээр зүйл. Рашаан ашиглагчийн эрх, үүрэг

14.1. Гэрээний дагуу рашаан ашиглаж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага дараахь эрх, үүрэгтэй:

14.1.1. холбогдох хууль тогтоомж болон рашаан ашиглах гэрээнд заасан үүргээ бүрэн биелүүлсэн бол гэрээний хугацаа дууссан тохиолдолд рашааныг үргэлжлүүлэн ашиглахаар гэрээгээ сунгуулах;

14.1.2. рашаан, түүний чанарыг хамгаалах, зохиустой ашиглах тухай хууль тогтоомж, гэрээнд заасан нөхцөл, болзлыг биелүүлэх;

14.1.3. рашаан, түүний чанарыг хамгаалах арга хэмжээг жил бүр төлөвлөн хэрэгжүүлэх;

14.1.4. рашаан ашиглалтын телбөрийг хугацаанд нь төлөх;

14.1.5. рашаан ашиглалтын бүртгэл, тайлан хөтөлж, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргад гэрээнд заасан хугацаанд өгөх.

ТАВДУГААР БҮЛЭГ

Бусад зүйл

15 дугаар зүйл. Рашаан ашигласны төлбөр

15.1. Рашаан ашиглаж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хуульд заасны дагуу нөөц баялаг ашигласны төлбөр төлнө.

15.2. Рашаан ашигласны төлбөрийн хэмжээ, төлбөрөөс чөлөөлөх, хөнгөлөх журмыг Ус, рашаан ашигласны төлбөрийн тухай хуулиар тогтооно.

15.3. Тухайн рашааны орд газар оршиж байгаа нутаг дэвсгэрийн сум, дүүргийн Засаг дарга рашаан ашигласны төлбөрийн 35-аас доошгүй хувийг рашааны орд, түүний чанарыг хамгаалах арга хэмжээнд зарцуулна.



16 дугаар зүйл. Рашааны тухай хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

16.1. Энэ хуулийг зөрчсөн гэм буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол эрх бүхий улсын байцаагч зөрчлийн шинж байдлыг харгалзан дараахь захиргааны шийтгэл ногдуулна:

16.1.1. энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасны дагуу рашаан бохирдохоос хамгаалах шаардлагыг биелүүлээгүй, тэдгээрийн эх үүсвэрийн хамгаалалтын болон ариун цэврийн бүсийн дэглэмийг зөрчсөн иргэнийг 20000-25000 хүртэл, албан тушаалтныг 25000-30000 хүртэл, хуулийн этгээдийг 150000-250000 хүртэл төгрөгөөр торгох;

16.1.2. рашааныг гэрээ, зөвшөөрөлгүй ашигласан буюу горимын хэмжээнээс хэтрүүлэн гэрээгүйгээр ашигласан, эсхүл зориулалтыг дур мэдэн өөрчилсөн бол хууль бусаар олсон орлогыг хурааж, зөрчил гаргасан иргэнийг 25000-30000 хүртэл, албан тушаалтныг 35000-40000 хүртэл, хуулийн этгээдийг 140000-150000 хүртэл төгрөгөөр торгох.

16.2. Рашаан ашиглах журмыг зөрчсөн тохиолдолд ашиглах эрхийг нь хүчингүй болгох, эсхүл түдгэлзүүлнэ. Рашааныг ашиглах эрхийг хүчингүй болгох, хязгаарлах, зогсоох нь гэм буруутай этгээдийг хууль тогтоомжид заасан өөр төрлийн хариуцлагаас чөлөөлөхгүй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА

Ж.БЯМБАДОРЖ

2003 оны 11 дүгээр сарын 7-ны өдөр

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

Улаанбаатар хот

ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эрүүл мэндийн тухай хуульд дор дурдсан агуулгатай 26¹ дугаар зүйл нэмсүгэй:

26¹ дугаар зүйл. Эмнэлгийн мэргэжилтний нийгмийн баталгаа

26¹.1. Эмнэлгийн мэргэжилтэн нийгмийн дараахь баталгаагаар хангагдана:

26¹.1.1. эрүүл мэндийн байгууллагад 25 ба түүнээс дээш жил ажилласан эмнэлгийн мэргэжилтэнд тэтгэвэрт гарахад нь 12 сарын, үүнээс сум, тосгон, сум дундын эмнэлэгт 10 ба түүнээс дээш жил ажилласан эмнэлгийн мэргэжилтэнд 18 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тусламжийг ажиллаж байгаа эрүүл мэндийн байгууллагаас нь нэг удаа олгох;

26¹.1.2. орон нутгийн хурал, захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага эмнэлгийн мэргэжилтэнд нэмэгдэл цалин, урамшил олгох, дэмжлэг үзүүлэх;

26¹.1.3. хуульд заасан бусад баталгаа.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2004 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА

Ж.БЯМБАДОРЖ

2003 оны 11 дүгээр сарын 7-ны өдөр

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

Улаанбаатар хот

СОГТУУРУУЛАХ УНДАА ХЭТРҮҮЛЭН ХЭРЭГЛЭСЭН ЭТГЭЭДИЙГ АЛБАДАН ЭРҮҮЛЖҮҮЛЭХ ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь нийгмийн хэв журам хамгаалах, түүнийг зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг цагдаагийн байгууллагын хяналтад авч, эмнэлгийн үйлчилгээ

үзүүлж, албадан эрүүлжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай хууль тогтоомж

2.1. Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль¹, Архидан согтуурахтай тэмцэх тухай², Цагдаагийн

¹Монгол Улсын Үндсэн хууль - "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1992 оны 1 дүгээрт нийтлэгдсэн.

²Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль - "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2000 оны 6 дугаарт нийтлэгдсэн.

³Цагдаагийн байгууллагын тухай хууль - "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1993 оны 8 дугаарт нийтлэгдсэн.

байгууллагын тухай хууль³, энэ хууль болон хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

3 дугаар зүйл. Хуулийн нэр томьёоны тодорхойлолт

3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1. "согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээд" гэж өөрийн үйлдлийг удирдан хянах чадваргүй болтлоо согтсон этгээдийг;

3.1.2. "албадан эрүүлжүүлэх" гэж согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийн өөрийн үйлдлээ удирдан хянах чадварыг нь сэргээх үйл ажиллагааг;

3.1.3. "эрүүлжүүлэх байр" гэж албадан эрүүлжүүлэх үйл ажиллагаа явуулах тусгай байрыг;

3.1.4. "хамгаалах хүн" гэж согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийн гэр бүлийн гишүүн, төрөл садангийн хүн болон уг этгээдийг таньдаг бөгөөд түүнийг харгалзан хамгаалж авч явах боломжтой, насанд хүрсэн этгээдийг.

4 дүгээр зүйл. Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх зарчим

4.1. Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэхдээ хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, хууль дээдлэх, хүнлэг энэрэнгүй ёсыг эрхэмлэн нийгмийн аюулгүй байдлыг хангах, хүн амын эрүүл мэндийг хамгаалах зарчмыг баримтална.

5 дугаар зүйл. Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг эрүүлжүүлэх байранд хүргэх үндэслэл

5.1. Өөрийн үйлдлийг удирдан хянах чадваргүй болтлоо согтсоны улмаас гэр бүлийн буюу бусдын амгалан тайван байдлыг алдагдуулсан, хаана байгаагаар болон очих газраа мэдэхгүй болсон, гудамж талбай, олон нийтийн газар ухаангүй унасан, энэ байдлаас болж гэмт хэрэг үйлдэх, захиргааны зөрчил гаргах, мөн өөрөө осол гэмтэл, гэмт хэрэг, зөрчилд өртөж болзошгүй болсныг үндэслэл болгон цагдаагийн алба хаагч тухайн этгээдийг хамгаалах, тусламж үзүүлэх зорилгоор эрүүлжүүлэх байранд хүргэнэ.

5.2. Энэ хуулийн 5.1-д заасныг үндэслэн иргэн санаачлан согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг эрүүлжүүлэх байранд хүргэж болно.

5.3. Согтууруулах ундаа хэрэглэсэн боловч өөрийн үйлдлээ удирдан хянах чадвартай, зөрчил гаргаагүй хүнийг эрүүлжүүлэх байранд албадан хүргэхийг хориглоно.

5.4. Гадаадын иргэн, харъяалалгүй хүнийг албадан эрүүлжүүлэхэд хууль тогтоомж, Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол энэ хуулийг дагаж мөрдөнө.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Эрүүлжүүлэх байр, түүний ажилтны эрх, үүрэг, эрүүлжүүлэх байрны нөхцөл, журам

6 дугаар зүйл. Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх байр

6.1. Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тусгай байр нь аймаг, нийслэлд эрүүлжүүлэх байр нэртэйгээр байна.

6.2. Эрүүлжүүлэх байр нь цагдаагийн төв байгууллагын харъяалалд ажиллана.

6.3. Аймаг, нийслэлийн эрүүлжүүлэх байрны орон тоо, үйл ажиллагааны бүтэц, зохион байгуулалтыг цагдаагийн төв байгууллагын даргын саналыг үндэслэн хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.

7 дугаар зүйл. Эрүүлжүүлэх байрны ажилтан, түүний эрх, үүрэг

7.1. Эрүүлжүүлэх байранд ажиллаж байгаа цагдаагийн алба хаагч нь цагдаагийн байгууллагын ажилтны эрх эдэлж, үүрэг хүлээх бөгөөд эрүүлжүүлэх байранд дэг журам сахиулж, эрүүлжүүлэх байрны ажилтнууд, үйлчлүүлж байгаа хүмүүсийн аюулгүй байдлыг хангаж, байрны хамгаалалтыг хариуцна.

7.2. Эрүүлжүүлэх байр нь мэргэжлийн эмчтэй байх бөгөөд тэр нь эмчийн ёс зүйн хэм хэмжээг сахиж, цагдаагийн болон эмнэлгийн ажилтны эрх эдэлж, үүрэг хүлээн, согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдэд эмнэлгийн үйлчилгээг шуурхай үзүүлж ажиллана.

7.3. Эрүүлжүүлэх байрны ажилтанд дараахь зүйл хийхийг хориглоно:

7.3.1. албадан эрүүлжүүлэх / цаашид "эрүүлжүүлэх" гэх/ шаардлагатай этгээдийг хүлээн авахаас татгалзах;

7.3.2. эрүүлжүүлэх буюу согтууг гаргах эмчилгээг хийхгүй байх, дутуу хийх;



7.3.3. үйлчлүүлэгч этгээдтэй хүнлэг бус харьцах;

7.3.4. үйлчлүүлэгч этгээдийг эрүүлжүүлэх байранд байх хугацаанд олж мэдсэн хувь хүний нууцыг задруулах, нэр хүндэд нь халдсан мэдээлэл тараах;

7.3.5. үйлчлүүлэгч этгээдийн биедээ авч явсан баримт бичиг, мөнгө, хувцас, эд зүйлийг ашиглах, үрэгдүүлэх, гэмтээх;

7.3.6. эрүүлжүүлэх шаардлагагүй этгээдийг хүлээн авах.

8 дугаар зүйл. Эрүүлжүүлэх байранд хүлээн авах

8.1. Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг хүргэж ирсэн цагдаагийн алба хаагч буюу иргэнийг байлцуулан эрүүлжүүлэх байрны эмч уг этгээдийн эрүүл мэндийн байдалд үзлэг хийж, энэ тухай тэмдэглэл хөтөлж, эрүүлжүүлэх байранд хүлээж авна.

8.2. Эрүүлжүүлэх байрны цагдаагийн алба хаагч нь согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг хүргэж ирсэн хүн болон гэрчийн этгээдийг байлцуулан түүний биедээ авч яваа баримт бичиг, мөнгө, хувцас, эд зүйлийг хаяж, үрэгдүүлэхээс сэргийлж, тоо хэмжээ, содон шинж тэмдгийг нэг бүрчлэн тэмдэглэлд тусгаж, түр авч хадгална.

8.3. Тэмдэглэлд түр хадгалах зүйлийг хүлээн авсан цагдаагийн алба хаагч, үйлчлүүлэгч этгээд, түүнийг хүргэж ирсэн хүн болон гэрчийн этгээд гарын үсэг зурах бөгөөд үйлчлүүлэгч этгээд гарын үсэг зурж чадахгүй бол цагдаагийн алба хаагч тэр тухай тайлбар бичнэ.

8.4. Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг эрүүлжүүлэх байранд хүлээн авсны дараа цагдаагийн алба хаагч боломжтой бол энэ тухай түүний гэр бүлийн насанд хүрсэн этгээдэд нь мэдэгдэх арга хэмжээ авна.

8.5. Насанд хүрээгүй этгээд согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэж, эрүүлжүүлэх байранд хүргэгдэн ирсэн тохиолдолд эрүүлжүүлэх байрны цагдаагийн алба хаагч уг этгээдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчтэй холбоо тогтоож, тэдэнд хүлээлгэн өгөх арга хэмжээ авна. Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчтэй нь холбоо тогтоох боломжгүй бол насанд хүрээгүй этгээдийг эрүүлжүүлэх байранд хүлээн авна.

8.6. Эрүүлжүүлэх байранд үйлчлүүлэгч этгээд амиа хорлох, бусдад халдан довтлоход ашиглаж болох эд зүйл оруулахыг хориглоно.

8.7. Үйлчлүүлэгч этгээдээс галт зэвсэг, хутга мэс, амьсгал боогдуулах, нулимс асгаруулах, мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодис илэрвэл цагдаагийн алба хаагч түр хураан авч, шалгах эрх бүхий байгууллагад шилжүүлнэ.

8.8. Дор дурдсан этгээдийг эрүүлжүүлэх байранд хүлээн авахгүйгээр эмнэлгийн түргэн тусламж дуудаж шилжүүлж өгнө:

8.8.1. нарийн мэргэжлийн эмчийн яаралтай тусламж үзүүлэх шаардлагатай гэмтэл биедээ авсан, хүнд болон халдварт өвчтэй;

8.8.2. мансууруулах бодис хэрэглэж хордсон нь тогтоогдсон.

9 дүгээр зүйл. Эрүүлжүүлэх байрны нөхцөл, үйлчилгээ үзүүлэх журам

9.1. Эрүүлжүүлэх байрны нөхцөл, түүнд тавигдах ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага, эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх журам, зайлшгүй шаардлагатай эм, тариа, эмнэлгийн багаж хэрэгслийн жагсаалтыг эрүүл мэндийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтоож, стандартаар батлуулна.

9.2. Үйлчлүүлэгч этгээдийг насанд хүрсэн болон насанд хүрээгүй, эрэгтэй, эмэгтэйдээр нь тус тусад нь байлгана.

9.3. Үйлчлүүлэгч этгээдэд эрүүлжүүлэх үйлчилгээ үзүүлсэнтэй холбогдон хөтөлсөн баримт бичгийг нэгтгэн архивын нэгж үүсгэн хадгална.

10 дугаар зүйл. Тусгаарлах өрөө

10.1. Эрүүлжүүлэх байр нь үйлчлүүлэгчдийн аюулгүй байдлыг хангах зорилгоор тусгаарлах өрөөтэй байна.

10.2. Тусгаарлах өрөөний цонх нь сараалжин хамгаалалттай, хаалга нь гадна талаасаа түгжээтэй, хянах шагайвартай, гааржуулах салхивчтай, модон шалтай байна.

10.3. Үйлчлүүлэгч этгээд догшин хэрцгий авирлаж, бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулахаар бол уг этгээдийг зургаан цаг хүртэл хугацаагаар тусгаарлах өрөөнд нэг удаа байлгаж болно.

10.4. Гэмт хэрэг, захиргааны зөрчилд сэрдэгдэж байгаа этгээдийг тусгаарлах өрөөнд байлгаж, эрүүлжүүлсний дараа нэг цагийн дотор

хэрэг, зөрчлийг шалгаж шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтанд шилжүүлнэ.

10.5.Цагдаагийн алба хаагч тухайн этгээдийг тусгаарлах өрөөнд байлгах үндэслэл, тусгаарлах өрөөнд орсон, гарсан цаг, хугацааг нарийвчлан тусгасан тэмдэглэл үйлдэнэ.

11 дүгээр зүйл. Эрүүлжүүлэх байранд байлгах хугацаа

11.1.Үйлчлүүлэгч этгээдэд эрүүлжүүлэх эмнэлгийн үйлчилгээ үзүүлж, эрүүлжүүлэх байранд 24 цаг хүртэл хугацаагаар байлгаж болно.

12 дугаар зүйл. Эрүүлжүүлэх байрнаас гаргах

12.1.Эрүүлжүүлэх анхан шатны тусламж авч, өөрийн үйлдлийг удирдан хянах чадвартай болсон этгээдийг эмчийн дүгнэлтийг үндэслэн эрүүлжүүлэх байрнаас гаргах бөгөөд энэ тохиолдолд хамгаалах хүн шаардагдахгүй.

12.2.Үйлчлүүлэгч этгээдийн аюулгүй байдлыг хангах зорилгоор эрүүлжүүлэх байрнаас өдрийн цагаар гаргана.

12.3.Үйлчлүүлэгч этгээдийг гарах үед цагдаагийн алба хаагч түүний гарын хэзэ болон гэрэл зургийг санд хадгалахаар авах ба түр хадгалсан баримт бичиг, мөнгө, хувцас, эд зүйлийг өөрт нь, эсхүл уг этгээдийг авахаар ирсэн хамгаалах хүнд гэрчийн этгээдийг байлцуулан тэмдэглэлийн дагуу хүлээлгэн өгч, гарын үсэг зуруулна.

12.4.Үйлчлүүлэгч этгээдэд хийсэн эмчилгээг болон эрүүлжүүлэх байрнаас гаргасан цаг, хугацааг тэмдэглэн авч, хадгална.

12.5.Эрүүлжүүлэх байрны алба хаагч нь уг байранд удаа дараа үйлчлүүлсэн этгээдийг согтууруулах донтой эсэхийг тогтоолгохоор холбогдох эмнэлгийн байгууллагад шилжүүлэх арга хэмжээ авна.

12.6.Эрүүлжүүлэх байр нь уг байранд үйлчлүүлсэн этгээдийн талаар мэдээллийн сантай байна.

13 дугаар зүйл. Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг хамгаалах хүнд хүлээлгэн өгөх

13.1.Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийн болон түүнийг хамгаалах хүний хүсэлтээр, эсхүл цагдаагийн алба хаагч өөрөө санаачлан тухайн этгээдийг эрүүлжүүлэх байранд хүргэхгүйгээр хамгаалах хүнд хүлээлгэн өгч болно.

13.2.Эрүүлжүүлэх байранд хүргэгдэн ирсэн этгээдийг хариуцан авахаар хамгаалах хүн ирсэн нөхцөлд тухайн этгээдийг хугацаа харгалзахгүй эрүүлжүүлэх байрнаас гаргаж, хамгаалах хүнд хүлээлгэн өгөх бөгөөд энэ тохиолдолд энэ хуулийн 12.1-д заасан эмчийн дүгнэлт шаардагдахгүй.

13.3.Цагдаагийн алба хаагч хамгаалах хүний баримт бичгийг шалгаж, хэнийг хэзээ, хаана, хэнд хүлээлгэн өгсөн, хүлээлгэн өгөх үед тухайн этгээдийн өмсөж явсан хувцас, биед нь байгаа баримт бичиг, мөнгө, эд зүйл, ил мэдэгдэх гэмтэл, шарх зэргийг дэлгэрэнгүй дурдсан тэмдэглэл хөтөлж, гарын үсэг зуруулна.

13.4.Хамгаалах хүсэлт гаргасан хүн нь баримт бичиггүй, өөрөө согтууруулах ундаа хэрэглэсэн, эсхүл тухайн этгээдийг хамгаалан авч явах боломжгүй тохиолдолд цагдаагийн алба хаагч хамгаалуулахаар хүлээлгэн өгөхгүй.

14 дүгээр зүйл. Эрүүлжүүлэх байрны санхүүжилт

14.1.Аймаг, нийслэл дэх эрүүлжүүлэх байрны зардлын санхүүжилт нь улс, орон нутгийн төсөв, эрүүлжүүлэх үйлчилгээний хөлс, хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэрээс бүрдэнэ.

14.2.Эрүүлжүүлэх үйлчилгээний хөлсний хэмжээ, үйлчилгээний хөлс төлөх журмыг хууль зүйн болон санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран тогтооно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Эрүүлжүүлэх байранд үйлчлүүлж байгаа этгээдийн эрх, үүрэг

15 дугаар зүйл. Эрүүлжүүлэх байранд үйлчлүүлж байгаа этгээдийн эрх

15.1.Эрүүлжүүлэх байранд үйлчлүүлж байгаа этгээд дараахь эрх эдэлнэ:

15.1.1. хувийн аюулгүй байдлыг хангуулах;

15.1.2.ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагад тохирсон нөхцөл, унтаж амрах боломжоор хангагдах;

15.1.3.гэр бүлийнхэнтэйгээ утсаар ярих, уулзах;

15.1.4.эмнэлгийн үйлчилгээг хуульд заасан журмын дагуу авах



15.1.5 өөрийн биед авч яваа баримт бичиг, мөнгө, эд зүйлийг түр хугацаагаар хадгалуулах;

15.1.6 хамгаалах хүн ирсэн нөхцөлд хугацаа харгалзахгүй эрүүлжүүлэх байрнаас гарах.

16 дугаар зүйл. Эрүүлжүүлэх байранд үйлчлүүлж байгаа этгээдийн үүрэг

16.1. Эрүүлжүүлэх байранд үйлчлүүлж байгаа этгээд дараахь үүрэг хүлээнэ:

16.1.1. Эрүүлжүүлэх үйлчилгээний хөлс төлөх;

16.1.2. Эрүүлжүүлэх байрны дотоод журмыг сахин биелүүлэх;

16.1.3. Архинд донтох өвчтэй нь нотлогдсон тохиолдолд эмчийн зөвлөмжийн дагуу цаашид эмчлүүлэх.

17 дугаар зүйл. Өргөдөл, гомдол гаргах

17.1. Эрүүлжүүлэх байранд үйлчлүүлсэн этгээд, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч эрүүлжүүлэхтэй холбогдсон өргөдөл, санал, гомдлыг эрүүлжүүлэх байрны үйл ажиллагаанд хяналт тавих эрх бүхий дээд шатны байгууллагад болон прокурорын байгууллага, шүүхэд гаргаж болно.

18 дугаар зүйл. Эрүүлжүүлэх үйл ажиллагаанд тавих хяналт

18.1. Эрүүлжүүлэх байрны үйл ажиллагаанд харъяалах дээд шатны байгууллагууд хяналт тавина.

18.2. Эрүүлжүүлэх байрны ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөлд мэргэжлийн хяналтын байгууллага хяналт тавина.

19 дүгээр зүйл. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

19.1. Эрүүлжүүлэх байрны ажилтан хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байх, эрхэлсэн ажилдаа хайнга хандах, эрх мэдлээ урвуулан ашиглах, үйлчлүүлэгч этгээдийн эрүүл мэнд, хууль ёсны эрх, ашиг сонирхолд хохирол учруулах, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангахгүй нөхцөлд эрүүлжүүлэх ажиллагаа явуулах зэргээр зөрчил гаргавал хууль тогтоомжийн дагуу сахилгын, захиргааны болон эрүүгийн хариуцлага хүлээнэ.

19.2. Энэ хуулийн 16.1.1-д заасныг зөрчсөн үйлчлүүлэгч этгээдээс эрүүлжүүлэх үйлчилгээний хөлс төлүүлэх асуудлыг шүүхийн журмаар шийдвэрлүүлнэ.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА

Ж.БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2003 оны 11 дүгээр сарын 7-ны өдөр

Улаанбаатар хот

ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ХЭСГИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

эрүүлжүүлэх тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА

Ж.БЯМБАДОРЖ

2 дугаар зүйл. Энэ хуулийг Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2003 оны 11 дүгээр сарын 7-ны өдөр

Улаанбаатар хот

"ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ХӨГЖИЛ-II" ТӨСЛИЙН ЗЭЭЛИЙН ГЭРЭЭГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улс, Азийн хөгжлийн банкны хооронд 2003 оны 8 дугаар сарын 25-ны өдөр байгуулсан "Эрүүл мэндийн салбарын хөгжил-II"

төслийн зээлийн гэрээг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА

Ж.БЯМБАДОРЖ



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2003 оны 11 дүгээр сарын 7-ны өдөр

Улаанбаатар хот

"УДААН ЗАДАРДАГ ОРГАНИК БОХИРДУУЛАГЧИЙН ТУХАЙ КОНВЕНЦИ"-Д НЭГДЭН ОРСНЫГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Швед Улсын Стокгольм хотноо 2001 оны 5 дугаар сарын 23-ны өдөр батлагдсан "Удаан задардаг органик бохирдуулагчийн тухай Конвенци"-д Монгол Улс

нэгдэн орсныг Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА

Ж.БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2003 оны 10 дугаар сарын 31-ний өдөр

Улаанбаатар хот

Дугаар 42

Газар зүйн нэрийн жагсаалт батлах тухай

Геодези, зураг зүйн тухай хуулийн 5.1.3-т заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

2/Газар зүйн нэрийн жагсаалтыг 4 жил тутам тодотгож, Улсын Их Хурлаар батлуулах.

1."Монгол Улсын нутаг дэвсгэрийн газар зүйн нэрийн жагсаалт"-ыг хавсралтаар баталсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

С.ТӨМӨР-ОЧИР

2.Монгол Улсын Засгийн газар /Н.Энхбаяр/-т даалгах нь:

1/Газар зүйн нэрийн жагсаалтыг судалгаанд хэрэглэх, албан хэрэг, олон нийтийн мэдээллийн хэрэгсэлд мөрдүүлэх, гадаад улс, олон улсын байгууллагатай нэр солилцох, мэдээлэх зэрэгт ашиглаж байх;

УНШИГЧДЫН АНХААРАЛД
Улсын Их Хурлын 2003 оны 42 дугаар тогтоолын хавсралт "Монгол Улсын нутаг дэвсгэрийн газар зүйн нэрийн жагсаалт" нь "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн хоёр жил илүүгийн дугааруудтай тэнцэх хэмжээтэй байгаа тул нийтлэх боломжгүй байна.
Иймээс Улсын Их Хурлын "www.parl.gov.mn" гэсэн вэб хуудасны "Хуулиуд" линк рүү орж танилцана уу.
Эмхтгэлийн зөвлөл

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2003 оны 11 дүгээр сарын 7-ны өдөр

Улаанбаатар хот

Дугаар 46

Тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн 23.3.4-ийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Улсын Засгийн газраас 2003 оны 9 дүгээр сарын 23-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх шаардлагагүй гэж үзэж хууль санаачлагчид нь буцаасугай.

1.Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай хуульд согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх үйлчилгээний хөлсний хэмжээ, хөлс төлөх журмыг хууль зүйн болон санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран тогтоохоор заасан тул Монгол

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА

Ж.БЯМБАДОРЖ



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2003 оны 10 дугаар сарын 28-ны өдөр

Дугаар 173

Улаанбаатар хот

Төрийн шагнал хүртээх тухай

"Монгол Улсын Төрийн шагналын тухай дүрэм"-ийн нэгийн 7, дөрвийн 1 дүгээр заалтуудыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Шинжлэх ухаан, технологи, урлаг соёлын салбарт оюуны үнэ цэнэтэй шилдэг бүтээл туурвисны учир

1. Монголын түүх, соёл, түүх бичлэгийн судалгааны цогц бүтээлийн ("**Монголын түүх бичлэг**" /XIII-XVII. II хэвлэл, Вашингтон 2002; "**Монголын түүх, соёл, түүх бичлэгийн судалгаа**" II боть, Токио 1994; III боть, УБ., 2001.) зохиогч Шагдарын Бира;

2. "Монументаль хүрэл хөшөө" /Ю.Цэдэнбал, Ж.Лхагвасүрэн, Ш.Отгонбилэг нарын/ уран баримлын гурвал бүтээлийн зохиогч Лхамсүрэнгийн Ганхуяг;

3. "Шилмэл ямаа сонгон үржүүлэх шинэ технологи" шинжлэх ухаан-үйлдвэрлэлийн технологийн хам бүтээлийн зохиогч Нянцаньямын Алтанхуяг, Ёндонгийн Загдсүрэн, Бэгзжавын Мандах нарт 2003 оны Монгол Улсын Төрийн шагнал хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2003 оны 11 дүгээр сарын 5-ны өдөр

Дугаар 174

Улаанбаатар хот

Дүрэм батлах тухай

1. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын дотоод дүрмийг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү зарлиг гарсантай холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 9 дүгээр

сарын 10-ны өдрийн 155 дугаар зарлигийг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Н. БАГАБАНДИ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2003 оны 174-р зарлигийн хавсралт

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН ДОТООД Д Ү Р Э М

1. Нийтлэг үндэслэл

1. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын Зөвлөл /цаашид Зөвлөл гэх/ нь үндэсний аюулгүй байдлыг хангах төрийн нэгдмэл бодлого боловсруулах үйл ажиллагаа болон түүнийг хэрэгжүүлэх ажлыг уялдлуулан зохицуулах, энэхүү зохицуулалт нь хэрхэн хангагдаж байгаад хяналт тавих төрийн зөвлөлдөх байгууллага мөн.

1.2. Зөвлөлийн дотоод ажил, хуралдааны дэг, Зөвлөлийн ажлын албаны чиг үүрэг, зохион байгуулалтыг энэхүү дүрмээр тогтооно.

1.3. Зөвлөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тухай хууль, Үндэсний аюулгүй байдлын тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомж, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Ерөнхийлөгчийн зарлигийг удирдлага болгон ажиллана.

1.4. Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь үндэсний аюулгүй байдлыг хангах бодлого, үйл ажиллагаатай холбогдсон асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх чиглэлийн талаар Монгол Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газарт зөвлөмж гаргах Зөвлөлийн хуралдаан байна.

1.5. Зөвлөл эрх хэмжээнийхээ асуудлыг хамтран хэлэлцэж, нэгдмэл саналаар шийдвэрлэнэ.

1.6. Зөвлөлийн үндсэн бүтцэд Зөвлөлийн тэргүүн, гишүүд, илтгэгч, зөвлөх, шинжээч, зөвлөлийн нарийн бичгийн дарга, ажлын алба багтана.

1.7. Зөвлөлийн нарийн бичгийн даргыг Монгол Улсын Ерөнхийлөгч томилно.

1.8. Зөвлөлийн нарийн бичгийн дарга Зөвлөлийн ажлын албаны үйл ажиллагааг Зөвлөлийн өмнө хариуцна.

1.9. Зөвлөл тогтоосон журмын дагуу үйлдсэн тамга, тэмдэг, хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

2. Зөвлөлийн ажлын дотоод зохион байгуулалт

Зөвлөлийн илтгэгч, зөвлөх, шинжээчдийн үүрэг, эрх:

2.1. Зөвлөлийн хуралдаанд илтгэгч, зөвлөх, шинжээч нар зөвлөх эрхтэй оролцоно.

2.2. Зөвлөлийн илтгэгчид нь хариуцсан салбартаа үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдлыг хангах ажлыг хариуцан, Зөвлөлийн гишүүний үүрэг даалгавар, Зөвлөлийн ажлын төлөвлөгөөний дагуу Зөвлөлийн хуралдаанд



тодорхой асуудлыг шаардлага хангасан түвшинд боловсруулан илтгэж, хуралдаанаас гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх үүрэгтэй. Илтгэгч нь хариуцсан салбарын бодлого, үйл ажиллагаа мөн улс орны дотоод амьдрал, олон улсын харилцааны онцгой үйл явдалтай холбогдсон үндэсний аюулгүй байдалд хор хохирол учруулж болзошгүй гэж үзсэн аливаа асуудлаар Зөвлөлийн тэргүүнд хандаж Зөвлөлийг хуралдуулах талаар санал гаргах эрхтэй. Илтгэгч нь гаргасан санал, Зөвлөлийн хуралдаанд оруулсан шийдвэрийн төслийн үндэслэлийг хариуцна.

2.3. Зөвлөлийн зөвлөх нь үндэсний аюулгүй байдалтай холбогдох аливаа асуудлаар байр сууриа илэрхийлж, авах арга хэмжээний болон Зөвлөлөөс гаргах шийдвэрийн төслийн талаарх саналаа танилцуулж Зөвлөлийн гишүүд, Зөвлөлийн нарийн бичгийн дарга, ажлын албанд зөвлөх үүрэгтэй. Үндэсний аюулгүй байдалд хор хохирол учруулж болзошгүй гэж үзсэн аливаа асуудлаар болон Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан санал, дүгнэлтээ Зөвлөлийн тэргүүн, гишүүнд танилцуулах эрхтэй. Зөвлөлийн зөвлөх нь гаргасан санал, өгсөн зөвлөгөөний үндэслэлийг хариуцна.

2.4. Зөвлөлийн шинжээч нь Зөвлөлийн гишүүд, ажлын албаны даалгавраар үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон тодорхой асуудлаар мэргэжлийн санал, дүгнэлт гаргах, Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэсэн илтгэгчийн илтгэл, шийдвэрийн төслийг шинжлэн, судалгаа, тооцооны үндэслэл, ашигласан мэдээллийн үнэн зөв эсэхийг нягталж дүгнэлт гаргах, ажлын албанаас нууцлалын талаар тавьсан шаардлагыг бүрэн биелүүлдэг үүрэгтэй. Шинжээч нь шаардлагатай бол шийдвэрийн төслийн өөр хувилбар боловсруулан танилцуулж болно.

Зөвлөлийн шинжээчид судалгааны үр дүн, санал дүгнэлтээ Зөвлөлийн хуралдаанд танилцуулж тайлбарлах, хүлээсэн үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай мэдээллийг цуглуулахад ажлын албанаас дэмжлэг авах, үндэсний аюулгүй байдлын тодорхой асуудлаар өөрийн санаачилгаар судалгаа хийж, Зөвлөлийн ажлын албанд танилцуулах, ажлын албаны томилолтоор гадаад, дотоодод ажиллах, судалгааны ажлынхаа үр дүнг өмчлөх эрхтэй. Зөвлөлийн шинжээчийн хувьд гүйцэтгэсэн судалгааны ажил, түүнд ашигласан мэдээллийг ажлын албаны зөвшөөрөлгүйгээр хэвлэн нийтлүүлэх, мэдээллийн хэрэгслээр олон нийтэд тараахыг хориглоно.

Шинжээчдийг төр, засгийн байгууллагын ажилтнуудаас томилохгүй байхыг эрмэлзэнэ.

Зөвлөлийн ажлын албаны үүрэг, эрх

2.5. Үндэсний аюулгүй байдлын зөвлөл хуулинд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд туслах нь ажлын албаны үндсэн үүрэг мөн.

2.6. Зөвлөлийн ажлын алба нь үйл ажиллагаагаа төрийн байгууллагуудаас хэрэгжүүлж байгаа үндэсний аюулгүй байдлыг хангах бодлого, үйл ажиллагааг Зөвлөлөөс уялдуулан зохицуулах, энэхүү зохицуулалт хэрхэн

хангагдаж байгаад Зөвлөлөөс хяналт тавих ажлыг зохион байгуулж чиглүүлнэ.

2.7. Зөвлөлийн ажлын алба ажлаа улирлаар төлөвлөж, төлөвлөгөөг Зөвлөлийн нарийн бичгийн дарга батална. Зөвлөлийн ажлын албаны ажилтнуудын хөдөлмөрийн харилцаатай холбогдсон асуудлыг хөдөлмөрийн дотоод журмаар зохицуулна.

2.8. Зөвлөлийн тэргүүн, гишүүдийн ажлын хэргэцээнд зориулан үндэсний аюулгүй байдлын холбогдолтой мэдээлэл бэлтгэнэ.

2.9. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын биелэлтэд хяналт тавьж, цаашид хэрэгжүүлэх талаар санал боловсруулна.

2.10. Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх асуудлын жилийн төлөвлөгөөг боловсруулна.

2.11. Зөвлөлийн хуралдаанд бэлтгэх, хуралдааныг зохион байгуулах, хуралдааны тэмдэглэл хөтлөх, хуралдааны хамгаалалтыг зохион байгуулна.

2.12. Зөвлөлийн шийдвэр, баримт бичгийг холбогдох байгууллагад танилцуулах, хүргүүлэх, Зөвлөлийн шийдвэрийн биелэлтийг гаргуулан, гүйцэтгэлд нь хяналт тавина.

2.13. Зөвлөлөөс төрийн байгууллагатай харилцах ажлыг зохион байгуулж, Зөвлөлийн нэр дээр ирсэн мэдээлэл, санал, хүсэлтийг нэгтгэн судалж, удирдлагад танилцуулж, хянан шийдвэрлүүлнэ.

2.14. Зөвлөлийн ажлын хэсэг байгуулж ажиллуулахад тусалж, Зөвлөлийн зөвлөх, шинжээч нарыг мэдээллээр хангах ажлыг гүйцэтгэнэ.

2.15. Хуралдааны болон Зөвлөлийн ажлын хэсэг ажиллах, техник, зохион байгуулалтын бэлтгэлийг хангаж, хуралдааны танхим, техник хэрэгслийг бэлэн байлгана.

2.16. Зөвлөлийн архив, мэдээллийн санг бүрдүүлж, Зөвлөлийн бичиг хэргийг хөтлөн явуулна.

2.17. Илтгэгчийн илтгэл, шийдвэрийн төслийн талаар санал, дүгнэлт гаргана.

2.18. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын биелэлтийн явцын талаар дүгнэлт гаргана.

2.19. Зөвлөлийн бүрэн эрхийг хэрэгжүүлэхэд шаардлагатай тоо баримт, мэдээ, мэдээлэл, судалгаа, баримт төрийн болон төрийн бус байгууллага, албан тушаалтнаас гаргуулан авна.

2.20. Үндэсний аюулгүй байдалтай холбоотой судалгаа, шинжилгээний төслийг шинжлэх ухаан технологийн сан болон бусад эх үүсвэрээс санхүүжүүлэхээр захиална.

2.21. Зөвлөлийн чиг үүрэг, бүрэн эрх хэмжээний асуудлаар судалгаа хийж, асуудал боловсруулахад зохих мэргэжлийн хүмүүсийг татан оролцуулна.



2.22. Зөвлөлийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг бүтээгдэхүүний хэлбэрээр нийлүүлж, түүнийхээ төлөө улсын төсвөөс санхүүжилт авч, батлагдсан төсвийн зориулалтын дагуу зарцуулна.

2.23. Ажлын алба нь тогтоосон журмын дагуу үйлдсэн тушаалын хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

Зөвлөлийн нарийн бичгийн даргын үүрэг, эрх:

2.24. Зөвлөлийн тэргүүн, гишүүд хуулинд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд туслах нь Зөвлөлийн нарийн бичгийн даргын үндсэн чиг үүрэг мөн.

2.25. Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх асуудлын жилийн төлөвлөгөөг Зөвлөлийн тэргүүнээр батлуулна.

2.26. Зөвлөлийн хуралдаанаас гаргах шийдвэрийн үндэслэлийг боловсруулах ажлыг зохион байгуулж, Зөвлөлийн илтгэгч, зөвлөхийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулна.

2.27. Зөвлөлийн шийдвэрийн биелэлтэд хяналт тавьж ажлыг зохион байгуулна.

2.28. Зөвлөлийн тэргүүн, гишүүдэд үндэсний аюулгүй байдлын холбогдолтой судалгаа, мэдээллийг танилцуулна.

2.29. Зөвлөлийн ажлын албаны улирлын ажлын төлөвлөгөө болон ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг баталж, жилийн ажлын тайлан, улирлын ажлын дүнг хянан үзэж Зөвлөлийн тэргүүнд илтгэнэ. Зөвлөлийн тамгыг түшнэ.

2.30. Зөвлөлийн ажлын дотоод дүрэм, мэдээллээр хангах журам, үндэсний аюулгүй байдлыг хангах асуудлааар мэдээлэл солилцох, зөвлөлдөх орон тооны бус байнгын ажлын хэсгүүдийн ажиллах журмыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, эдгээр дүрэм, журамд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг Зөвлөлийн тэргүүнд танилцуулна.

2.31. Зөвлөлийн ажлын албаны болон үйл ажиллагаатай холбоотой журмуудыг баталж, хяналт тавьж ажиллана.

2.32. Зөвлөлийн тэргүүний чиглэл болгосноор гадаадын ижил төстэй байгууллагатай үндэсний ашиг сонирхолын үүднээс харилцаа тогтоох, хамтран ажиллах ажлыг хариуцна.

2.33. Зөвлөлийн ажлын хэсэг байгуулах талаарх саналаа Зөвлөлийн тэргүүнд танилцуулна.

2.34. Зөвлөлийн нарийн бичгийн дарга нь үүргээ хэрэгжүүлэхдээ Зөвлөлийн тэргүүн, гишүүд, илтгэгч, зөвлөх, Улсын Их Хурал, Засгийн газар, төрийн захиргааны төв байгууллага, тэдгээрийн харьяа багууллага, нутгийн захиргааны удирдлагатай шууд харилцаж ажиллана.

2.35. Эрх хэмжээнийхээ асуудлаар Монгол Улсын хууль, тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, шийдвэрт нийцүүлэн захирамж гаргаж, биелэлтийг нь хангуулна.

2.36. Зөвлөлийн тэргүүн, гишүүдээс өгсөн чиглэлийн дагуу Зөвлөлийн чиг үүрэгт хамаарах асуудлаар холбогдох байгууллагад шалган танилцаж, Зөвлөлийн шийдвэрийг хэрэгжүүлэх болон үндэсний аюулгүй байдлыг хангахад чиглэсэн төрийн байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулахтай холбогдсон асуудлаар албан тушаалтанд шаардлага тавина.

2.37. Зөвлөлийн шинжээчээр томилуулах саналыг Монгол Улсын ерөнхийлөгчид танилцуулж, Зөвлөлийн тэргүүний чиглэл болгосноор шинжээчдэд үүрэг даалгавар өгнө.

2.38. Монгол Улсын үндэсний аюулгүй байдал хэрхэн хангагдаж байгаа талаар Улсын Их Хуралд мэдээлнэ.

2.39. Дэвшүүлсэн хэтийн зорилтоо хэрэгжүүлэхэд төрийн зохицуулалт шаардлагатай бол холбогдох эрх бүхий байгууллагад санал оруулна.

2.40. Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан Төсвийн ерөнхийлөн захирагчийн бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

2.41. Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээр өмчийн оролцоотой хуулийн этгээд, бусад хуулийн этгээдээс эрхлэх ажлын хүрээнд шаардлагатай бүтээгдэхүүнийг худалдан авч болно.

2.42. Ажлын албаны даргыг уг албан тушаалд нэр дэвшүүлсэн хүмүүсээс сонголт хийж, Төрийн албаны дүгнэлтийг үндэслэн томилж, чөлөөлнө.

2.43. Эрхэлсэн асуудлаараа өөрийн эрхийн хүрээнд Зөвлөлийг төлөөлж аль ч байгууллагад чөлөөтэй нэвтэрч, холбогдох албан тушаалтантай хүлээгдэлгүй уулзаж болно.

2.44. Зөвлөлийн нарийн бичгийн дарга нь уналга, холбооны хэрэгсэл, Засгийн газрын гишүүн-сайдын нэгэн адил хангамж, нөхцлөөр хангагдана.

2.45. Зөвлөлийн Тэргүүний өгсөн үүрэг чиглэлийг холбогдох байгууллага, хүмүүст уламжлан биелэлтэд хяналт тавина.

Зөвлөлийн ажлын албаны даргын үүрэг, эрх

2.46. Зөвлөлийн ажлын албыг удирдаж, ажилтнуудын ажлыг дүгнэх, ажиллах нөхцөл бололцоог бүрдүүлэх ажлыг хариуцан зохион байгуулна.

2.47. Зөвлөлийн чиг үүрэг, бүрэн эрхийн асуудлаар судалгаа хийх, асуудал боловсруулахад зохих мэргэжлийн хүмүүсийг татан оролцуулна.

2.48. Зөвлөлөөс төрийн байгууллагуудтай харилцах ажлыг зохион байгуулж, Зөвлөлийн нэр дээр ирсэн мэдээлэл, санал, хүсэлтийг нэгтгэн судалж, Зөвлөлийн нарийн бичгийн даргад танилцуулж, хянан шийдвэрлүүлнэ.

2.49. Зөвлөлийн хуралдааны бэлтгэлийг хангуулан, хуралдаанаас гаргах зөвлөмж, тэмдэглэл, хуралдааны талаарх хэвлэлийн мэдээллийг цаг хугацаанд нь гаргах ажлыг зохион байгуулна.

2.50. Зөвлөлийн нарийн бичгийн даргатай зөвшилцөн Зөвлөлийн шинжээчид, эрдэмтэн, судлаачдаар үндэсний аюулгүй байдалтай холбоотой асуудлаар Гэрээ байгуулан судалгаа шинжилгээний ажил гүйцэтгүүлж, үнэлэлт дүгнэлт хийнэ.

2.51. Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 17 дугаар зүйлд заасан Ерөнхий менежерийн бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

2.52. Ажлын албанд шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрмжийг олж захиалан нийлүүлж, Зөвлөлийн мэдээллийн сан, компьютерийн дотоод болон интернетийн сүлжээний байнгын найдвартай ажиллагааг хангуулах, программ хангамжийг сайжруулах, вебсайтад болсон үйл явдлын тухай мэдээллүүдээр тогтмол баяжилт хийлгэх ажлыг зохион байгуулна.

2.53. Мөрдөж байгаа хууль тогтоомж, батлагдсан орон тоо, албан тушаалын зэрэглэлд нийцүүлэн ажлын албаны төсөв боловсруулан батлуулж, ажилтан, шинжээчийн цалин, хөнгөлөлт болон шинжээчийн урамшууллыг Зөвлөлийн нарийн бичгийн даргатай зөвшилцөн тогтооно.

2.54. YAБЗ-ийн төлөөлөгчид гадаад орнуудад, гадаадын ижил төстэй байгууллагаас манай улсад уригдан зочлох болон YAБЗ, ажлын албанаас зохион байгуулах хурал, зөвлөлгөөн, уулзалт, ярилцлагын бэлтгэлийг ханган зохион байгуулж, тэдгээрт шаардагдах зардлын төсвийг хийнэ.

2.55. YAБЗ-ийн нарийн бичгийн дарга буюу төсвийн ерөнхийлөн захирагчтай болон ажлын албаны ажилтнуудтай бүтээгдэхүүн нийлүүлэх үр дүнгийн гэрээ байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж, дүгнэнэ.

2.56. Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 17, 1, 3 ба 17.1.2, 17.1.15, 49 дүгээр заалтын дагуу Зөвлөлийн ажлын албаны нэр дээр данс нээх, ажлын албаны орон тоо, цалингийн санг тогтоох, ажилтнуудыг ажилд томилох, өөрчлөх, халах, тэдэнд урамшуулан олгох асуудлаар тушаал гаргана.

2.57. Жил бүр ажлын албаны үр дүнгийн гэрээ, жилийн ажлын тайлан болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдал хангагдаж буй талаар Улсын Их Хуралд мэдээлэх тайланг нэгтгэн, Зөвлөлийн нарийн бичгийн даргын захирамжууд, Зөвлөлийн дотоод дүрэм, ажилтнуудын ажил үүргийн хуваарь нэмэлт, өөрчлөлт оруулах зэрэг дотоод ажлын холбогдолтой зайлшгүй шаардлагатай баримт бичгүүдийг боловсруулна.

2.58. Ажлын албаны ажилтнуудаас ажил үүргээ гүйцэтгэж байгаа байдал, ажлын цаг ашиглалт, сахилга, дэг журам, албаны нууц хадгалалт хамгаалалтын байдалд хяналт тавьж ажиллана.

Ажлын албаны референт:

2.59. Үндэсний аюулгүй байдлын Зөвлөл хуулинд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь туслах явдал Зөвлөлийн ажлын албаны референтүүдийн үндсэн үүрэг мөн.

2.60. Ажлын албаны референтүүд нь хариуцсан ажлын чиг үүргийн дагуу төрийн нууцад хамаарах асуудлаар Зөвлөлийн нарийн бичгийн даргатай, энэхүү дүрэмд заасан үүрэг, эрхийнх нь хүрээний асуудлаар ажлын албаны даргатай харьцаж ажиллана.

2.61. Зөвлөлийн тэргүүн, гишүүдийн ажлын хэрэгцээнд зориулан үндэсний аюулгүй байдлын холбогдолтой мэдээлэл бэлтгэж, Зөвлөлийн нарийн бичгийн даргад танилцуулна.

2.62. Илтгэгчийн илтгэл, шийдвэрийн төслийн талаар санал, дүгнэлт гаргаж, Зөвлөлийн нарийн бичгийн даргад танилцуулж, Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэхэд бэлэн болгоно.

2.63. Зөвлөлийн бүрэн эрхийг хэрэгжүүлэхэд шаардлагатай тоо баримт, мэдээ, мэдээлэл, судалгаа, баримтыг төрийн болон төрийн бус байгууллага, албан тушаалтнаас гаргуулан авна.

2.64. Зөвлөлийн ажлын хэсэг байгуулж ажиллуулахад тусалж, Зөвлөлийн зөвлөх, шинжээч нарыг мэдээллээр хангах ажлыг гүйцэтгэнэ.

2.65. Зөвлөлийн нарийн бичгийн дарга болон ажлын албаны дарга үйл ажиллагаагаа явуулахад тусалж, мэргэжлийн зөвлөлгөө өгнө.

2.66. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын биелэлтийн явц болон хэрэгжүүлэх талаар санал боловсруулан Зөвлөлийн нарийн бичгийн даргад танилцуулна.

2.67. Хариуцсан ажилтай холбогдсон асуудлаар зарлиг, захирамж, бусад баримт бичгийн төслийг боловсруулж, гаргасан шийдвэр, өгсөн үүрэг, даалгаврын биелэлтийг зохион байгуулж, хяналт тавина.

2.68. Холбогдох байгууллагатай шууд харилцаж шуурхай мэдээ, лавлагаа авч, тэдгээрийг боловсруулан Зөвлөлийн нарийн бичгийн даргад танилцуулна.

2.69. Хариуцсан ажлын хүрээнд үндэсний аюулгүй байдлын холбогдолтой асуудлаар хийсэн судалгаа, шинжилгээг ашиглан холбогдох мэдээллийн санг бүрдүүлнэ.

2.70. Үндэсний аюулгүй байдлын асуудлаар мэдээлэл солилцох, зөвлөлдөх ажлын хэсгүүдийн ажилд дэмжлэг туслалцаа үзүүлнэ.



2.71. Үндэсний аюулгүй байдлын холбогдолтой асуудлаар Зөвлөлийн тэргүүн, гишүүд, нарийн бичгийн даргын хэлэх үг, илтгэл, ярианы сэдвийн төсөл боловсруулж, уулзалтад байлцан ярианы тэмдэглэл хөтөлж, нарийн бичгийн даргад танилцуулна.

2.72. Зөвлөлийн нарийн бичгийн даргын өгсөн үүрэг, даалгаврыг холбогдох байгууллага, албан тушаалтанд уламжилж, гүйцэтгэлийг илтгэнэ.

Төрийн нууцын хадгалалт, хамгаалалтын асуудал хариуцсан референт

2.73. Зөвлөлийн нарийн бичгийн даргын туслахын үүргийг гүйцэтгэж, түүний өдөр тутмын үйл ажиллагаа явуулахад нь тусалж өгсөн үүрэг даалгаврыг шуурхай биелүүлж ажиллана.

2.74. Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх асуудал, өдөр, цагийг Зөвлөлийн нарийн бичгийн дарга болон холбогдох бусад албан тушаалтантай зөвшилцөн төвлөж, хуралдааны байрыг бэлэн болгон шалгуулж, хуралдааны үеийн аюулгүй байдлыг хангаж ажиллана.

2.75. Зөвлөлийн хуралдаан болсон тухай хэвлэлийн мэдээг тухайн өдөрт нь багтаан бэлтгэж, төвийн хэвлэл, мэдээллийн хэрэгслүүдэд түгээн хүргэж, шуурхай мэдээлнэ.

2.76. Зөвлөлийн шийдвэрийн биелэлтийг холбогдох байгууллагаар гаргуулан авч, нэгтгэн Зөвлөлийн нарийн бичгийн даргад танилцуулна.

2.77. Төрийн нууц агуулсан албан бичиг баримтыг хүлээн авах, бүртгэх, хүргэх, шилжүүлэх, танилцуулах, олшруулах, хадгалах, устгах ажил холбогдох хууль тогтоомжийн дагуу явагдаж байгаа эсэх талаар ажлын албаны архив, нууц, бичиг хэрэг хариуцсан ажилтны үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллана.

Бичиг хэргийн эрхлэгч-операторч:

2.78. Нууц албан баримт бичгийг танилцуулах, хадгалалтад хяналт тавьж, түүнийг бичих, олшруулах, хүргүүлэх, эргүүлэн авахыг өөрийн биеэр хариуцан гүйцэтгэж, ирсэн нууц бичиг баримтыг хүлээн авч, бүртгэлийг зохих журмын дагуу хөтлөн Зөвлөлийн архив, мэдээллийн санг хариуцна.

2.79. Зөвлөлийн хуралдааны соронзон хальсны бичлэгийг цаасан дээр буулган Зөвлөлийн нарийн бичгийн даргад танилцуулж, тогтоосон журмын дагуу хадгална.

2.80. Зөвлөлд ирсэн албан бичиг, захидлыг хүлээн авч бүртгэх, картлах, холбогдох ажилтанд шилжүүлэх, ирсэн бичиг хэргийн бүртгэлийг хариуцна.

2.81. Зөвлөлийн хэмжээнд албан хэрэг хөтлөлтийг зохих зааврын дагуу хэрэгжүүлнэ.

2.82. Зөвлөлийн ажлын албаны мэдээллийн санд холбогдох өгөгдөхүүнийг оруулах, тэдгээрийг шинэчлэх ажлыг батлагдсан журам, ангиллын дагуу гүйцэтгэнэ.

2.83. Баримт бичгийг архивын зохих заавар, журмын дагуу хадгалж, тэдгээрийн нууцлалыг хамгаална.

2.84. Албан бичгийг зөвхөн албан хэрэгцээнд зориулан эрх бүхий албан тушаалтны зөвшөөрөл, тогтоосон тоогоор хувиан олшруулж, олшруулсан тухай бүртгэл хөтлөнө.

2.85. Зөвлөмж, тэмдэглэл, захирамж, албан бичгийн хэвлэмэл хуудас захиалан хэвлүүлж, хадгалалт, зарцуулалтад хяналт тавина.

3. Зөвлөлийн хуралдаан

3.1. Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг жил бүрийн нэгдүгээр сард багтаан Зөвлөлийн тэргүүн батална. Төлөвлөгөө нь үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг хэрэгжүүлэхэд чиглэнэ. Төлөвлөгөөнд тухайн асуудлын талаарх илтгэл, шийдвэрийн төслийг бэлтгэж ажлын албанд ирүүлэх хугацаа, илтгэх илтгэгч, ажлын албаанас хариуцах ажилтны нэрийг тус тус заана. Төлөвлөгөөнд улирал бүр тодотгол хийж, энэ талаар илтгэгчдэд Зөвлөлийн нарийн бичгийн дарга мэдэгдэнэ.

3.2. Үндэсний аюулгүй байдалд ноцтой нөлөөлж болохуйц тулгамдсан гэж үзсэн асуудлыг Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэхийг Зөвлөлийн аль нэг гишүүн эсвэл ажлын алба санал болгосноор Зөвлөлийн аль нэг гишүүн зөвшөөрснөөр хуралдаанаар яаралтай хэлэлцэнэ. Зөвлөлийн хуралдаанд оруулах илтгэгчийг уг асуудлыг хэлэлцэхийг санал болгосон Зөвлөлийн гишүүн тогтоож, мэдэгдэнэ.

3.3. Зөвлөлийн тэргүүн, гишүүн нь өөрийн бүрэн эрхийн хүрээнд үндэсний аюулгүй байдлын холбогдолтой асуудлыг Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэр гаргуулна.

3.4. Зөвлөлийн хуралдаанд Зөвлөлийн тэргүүн, гишүүд, Зөвлөлийн нарийн бичгийн дарга оролцсоноор хуралдааныг хүчинтэйд тооцно. Зөвлөлийн нарийн бичгийн даргын зэргүйд түүний үүргийг Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга гүйцэтгэнэ.

Зөвлөлийн хуралдаанд оролцох Зөвлөлийн зөвлөхийг хэлэлцэх асуудлын онцлогоос хамаарч Зөвлөлийн тэргүүний чиглэл болгосноор тогтоож байна. Зөвлөлийн хуралдаанд асуудал оруулах илтгэгчээс гадна хэлэлцэх асуудалтай холбогдуулан байлцах шинжээч, албан тушаалтан, мэргэжилтнийг Зөвлөлийн нарийн бичгийн дарга тогтооно.

3.5. Асуудлын онцлогоос хамааран Зөвлөлийн тэргүүн, гишүүд, Зөвлөлийн нарийн бичгийн дарга нар хуралдаж болох бөгөөд энэ тохиолдолд Зөвлөлийн нарийн бичгийн дарга хуралдааны тэмдэглэл хөтөлнө.

3.6. Зөвлөлийн хуралдаанд хэлэлцүүлэх асуудлын талаархи материалыг, үүнд илтгэгчийн хуралдаанд тавих илтгэл, гаргах шийдвэрийн төсөл, эдгээрт холбогдох бусад тооцоо судалгаа, мэдээллээс гадна шаардлагатай бол төрийн захиргааны төв бусад байгууллагын холбогдох саналыг илтгэгчийн гарын үсэг бүхий дагалдах

бичигтэйгээр "Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын Зөвлөлд" гэж хаяглан ирүүлнэ. Илтгэлд тухайн асуудлыг Зөвлөлөөр хэлэлцүүлэх болсон шаардлагыг үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын холбогдох заалттай холбон тодруулж, гаргах шийдвэрийн төсөл, түүний зорилго, зарчмын гол үндэслэл, шийдвэрийг гаргаснаар үндэсний аюулгүй байдлыг хангахад ямар ач холбогдолтойг хураангуйлан тодорхойлно.

3.7. Ажлын алба материалыг хүлээн аваад:

а/хуралдаанаас гаргах шийдвэрийн төслийг холбогдох хууль, тогтоомжийг удирдлага болгон үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхлын үүднээс нарийвчлан нягталж, үнэлэлт, дүгнэлт бүхий танилцуулга боловсруулна;

б/тогтоосон журам, шаардлагад нийцээгүй, дууту боловсруулсан илтгэл, шийдвэрийн төсөл, асуудлыг холбогдох газар, байгууллага /албан тушаалтан/-д нь бүрдлийг хангуулахаар буюу дахин боловсруулж ирүүлэхээр хугацаа заан буцаана;

в/асуудлыг судалж боловсруулсан байдал, үндэслэл нотолгоог Зөвлөлийн холбогдох шинжээчээр нягтлуулан, мэргэжлийн үнэлэлт, дүгнэлтийг гаргуулж, шаардлагатай гэж үзвэл Зөвлөлийн ажлын алба асуудлыг хянан боловсруулж шийдвэрийн өөр хувилбар дэвшүүлж болно;

г/асуудлыг хянан боловсруулахад илтгэгчээс гадна холбогдох бусад байгууллагын тухайн хариуцсан албан тушаалтан, мэргэжилтнийг оролцуулж, саналыг нь авч болно.

3.8. Зөвлөлийн хуралдаанд оруулахаар боловсруулсан шийдвэрийн төслийг хэлэлцэх эсэхийг Зөвлөлийн тэргүүн тогтоож, хуралдааныг төвлөнө.

3.9. Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх асуудлын материалыг хуралдаан болохоос 3-аас цөөнгүй хоногийн өмнө Зөвлөлийн тэргүүн, гишүүдэд Зөвлөлийн нарийн бичгийн дарга бүрэн багцаар нь танилцуулна. Яаралтай хэлэлцэх асуудлын хувьд энэ хугацаа хамаарахгүй. Илтгэгч, зөвлөх, шинжээч нарт, бусад оролцох хүмүүст материалын холбогдох хэсгийг нь Зөвлөлийн нарийн бичгийн даргын заалтын дагуу ажлын албаны нууцын асуудал хариуцсан референт хүргэнэ.

3.10. Хуралдаан дор дурдсан журмаар явагдана:

а/ хуралдааныг Зөвлөлийн тэргүүн даргална;

б/ хэлэлцэх асуудлын дэс дараагаар Зөвлөлийн илтгэгчийн илтгэлийг сонсоно. Шаардлагатай гэж үзвэл зөвлөх, шинжээч, ажлын албаны санал, дүгнэлт, танилцуулгыг сонсоно. Илтгэлийг танилцуулах хугацаа 15 минутаас, санал, дүгнэлтийг танилцуулах хугацаа 5 минутаас илүүгүй байна;

в/ хэлэлцэж буй асуудлаарх илтгэл, санал, дүгнэлтийг сонссоны дараа

Зөвлөлийн гишүүдээс илтгэгч, холбогдох албан тушаалтан, мэргэжилтэн, шинжээч нарт асуулт тавьж, хариулт авна;

г/ Зөвлөлийн гишүүд хэлэлцэж байгаа асуудал, илтгэгч болон ажлын албаны санал болгож байгаа шийдвэрийн төсөл төрийн бодлогод нийцэж байгаа эсэх талаар зөвлөх, шинжээчдийн санал дүгнэлттэй харьцуулан үнэлэлт өгч, зөвшөөрөх эсэхээ тодорхойлно. Хэрэв Зөвлөлийн тэргүүн, гишүүн шийдвэрийн төслийн агуулга, үндэслэл, заалтын талаар зарчмын өөр саналтай байгаа бол түүнийхээ үндэслэл, төсөлд оруулах нэмэлт, өөрчлөлтийн талаар саналаа хэлнэ;

д/ Зөвлөлийн тэргүүн хэлэлцэж буй асуудлаар гарсан саналыг нэгтгэн дүгнэж, шаардлагатай гэж үзвэл санал зөрөөтэй асуудлыг Зөвлөлийн гишүүдээр хэлэлцүүлнэ;

е/ Зөвлөлийн тэргүүн, гишүүд гаргах шийдвэрийн талаар зөвшилцөж, тохиролцсон шийдлийг томъёолно.

3.11. Зөвлөлийн хуралдааны тэмдэглэлийг Зөвлөлийн ажлын албаны бичиг хэргийн эрхлэгч-операторч гүйцэтгэж, дараах журмаар тэмдэглэл хөтөлнө:

а/ хуралдааны явцыг соронзон хальсанд бичнэ. Шаардлагатай гэж үзвэл хуралдааны дуутай дүрс бичлэг хийж болно;

б/ тэмдэглэлд дараах зүйлийг тусгана:

-хуралдаан эхэлсэн, завсарласан, дууссан он, сар, өдөр болон асуудлыг хэлэлцэж эхэлсэн, дууссан цаг, минут;

-асуудлыг хэлэлцэх болсон үндэслэл, шаардлагын тухай товч тэмдэглэл;

-Зөвлөлийн гишүүдийн тавьсан асуулт, түүнд өгсөн хариулт, хэлэлцэж буй асуудлаар хуралдаанд оролцогчдын гаргасан санал, хийсэн дүгнэлт, хэлсэн үг;

-Зөвлөлийн тэргүүн, гишүүдээс хэлэлцэж байгаа асуудал, шийдвэрийн төслийн талаар гаргасан санал, хэлсэн үг;

-Хуралдаан дээр тусгайлан тэмдэглүүлсэн зүйлийг тухайн албан тушаалтанд хянуулан гарын үсэг зуруулна.

3.12. Зөвлөлийн хуралдааны бүрэн тэмдэглэлийг Зөвлөлийн нарийн бичгийн дарга хянаж, гарын үсэг зурна.

3.13. Хэлэлцэх асуудал бүрт цаг тогтоохгүй боловч хуралдааныг 3 цагаас илүү үргэлжлүүлэхгүй байхаар зохион байгуулна.

3.14. Зөвлөлийн хуралдаан төрийн тусгай хамгаалалтад байна.



4.1. Зөвлөлийн хуралдаанаас гаргах шийдвэр нь зөвлөмж, тэмдэглэл байна. Зөвлөмжийг бодлогын холбогдолтой асуудлаар гаргаж, Зөвлөлийн хуралдаанаас өгсөн зохион байгуулалтын шинжтэй үүрэг, даалгаврыг хуралдааны тэмдэглэлд тэмдэглэнэ.

4.2. Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэж, нэгдмэл саналаар гаргасан шийдвэрт, хуралдаанаас хойш зарчмын өөрчлөлт оруулахыг хоригоно.

4.3. Зөвлөмжид Зөвлөлийн тэргүүн, гишүүд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно. Бүрэн эрхэд нь холбогдох асуудлаарх зөвлөмжийн эх хувийг Улсын Их Хурал, Засгийн газарт болон Засгийн газрын холбогдох гишүүн, төрийн захиргааны төв байгууллагад Зөвлөлийн нарийн бичгийн даргын гарын үсэгтэй баталгаажуулсан хуулбарыг хүргүүлнэ. Тэмдэглэлийн холбогдох заалтыг хэрэгжүүлэгч байгууллагад Зөвлөлийн нарийн бичгийн даргын гарын үсэгтэйгээр хүргүүлнэ. Зөвлөмжийн биелэлтэд Зөвлөлийн уг асуудлыг эрхэлж буй гишүүн хяналт тавина.

4.4. Зөвлөлийн хуралдаанаар зайлшгүй хэлэлцүүлэх зохих асуудлыг цаг алдалгүй шийдвэрлэхийн тулд Зөвлөлийн тэргүүн, гишүүдийн саналыг Зөвлөлийн нарийн бичгийн дарга авах замаар ажлын журмаар шийдвэр гаргаж болно.

4.5. Зөвлөлийн шийдвэрийг Засгийн газар биелүүлэх арга хэмжээ авч, энэ тухай Зөвлөлийн тэргүүнд мэдээлнэ.

4.6. Засгийн газрын гишүүн, ЗХЖШ-ын дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга, ИТХТ-ийн дарга, Засгийн газрын агентлагийн дарга Зөвлөлийн шийдвэрийг хүлээн авмагц хэрэгжүүлэхэд чиглэсэн шийдвэрийг эрх хэмжээнийхээ хүрээнд гаргаж, хариуцах эзэн, гүйцэтгэх хугацааг тодорхой заасан тушаал, албан даалгавар гаргаж гүйцэтгэлд нь байнга хяналт тавьж, тэдгээрийг бүрэн биелүүлэх арга хэмжээ авч, дүнг Зөвлөлд тогтоосон хугацаанд бичгээр илтгэх үүрэгтэй.

4.7. Зөвлөлийн шийдвэрийн биелэлтийг Зөвлөлийн нарийн бичгийн дарга Зөвлөлийн тэргүүнд тухай бүрт нь илтгэж, Зөвлөлийн гишүүдэд тогтмол мэдээлж байна.

4.8. Хуралдааны тухай тэмдэглэл, соронзон бичлэгийг ашиглахдаа дараахь журмыг баримтална:

-Зөвлөлийн тэргүүн, гишүүдээс ажлын хэрэгцээндээ ашиглах хуралдааны тэмдэглэл, бичлэг, дискетийг Зөвлөлийн ажлын албаны архив, нууц хариуцсан референт биечлэн өгч, хүлээн авна;

-хуралдааны явцын соронзон бичлэг, тэмдэглэлийг хадгалсан дискет, дуутай дүрс бичлэг, албан ёсны тэмдэглэлийг тухайн хуралдааны болон Зөвлөлийн үйл ажиллагааны тухай лавлагаа гаргах, хэлэлцсэн асуудалтай холбоотой маргаантай асуудал шийдвэрлэхэд Зөвлөлийн нарийн бичгийн даргын зөвшөөрлөөр ашиглуулж, үзүүлж, сонсоно;

-дээрх материалыг зөвхөн нууцын асуудал хариуцсан ажилтны дэргэд танилцаж, үзэж, сонсох бөгөөд тэдгээрийг олшруулах, хувилахыг хориглоно;

-соронзон болон дуутай дүрс бичлэгийг архивт хадгална.

5. Зөвлөлийн судалгаа, мэдээлэл

5.1. Үндэсний аюулгүй байдалд сөрөг нөлөөлөх буюу хор хохирол учруулж болзошгүй гэж үзсэн тодорхой асуудлыг судлан үнэлэлт өгч, санал, дүгнэлт гаргах зорилгоор Зөвлөлийн ажлын хэсгийг байгуулж ажиллуулна. Ажлын хэсгийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн захирамжаар томилж, гүйцэтгэх ажил, түүнийг биелүүлэх хугацаа, хариуцлага, урамшууллыг Зөвлөлийн нарийн бичгийн дарга тогтооно. Ажиллах тодорхой хугацаа нь дуусмагц ажлын хэсэг тарсанд тооцно. Ажлын хэсгийг Зөвлөлийн зөвлөх, шинжээч тэргүүлнэ.

5.2. Зөвлөл нь үндэсний аюулгүй байдлыг тал бүрээс нь судалж, аюулгүй байдалд сөрөг нөлөөлөх үйл явдал, хандлагаас сэрэмжлэхэд чиглэсэн зөвлөмж, санал, дүгнэлтийг Зөвлөл, төрийн байгууллагуудын ажлын хэрэгцээнд зориулан боловсруулах чиг үүрэгтэй эрдэм шинжилгээний бие даасан нэгжтэй байж болно. Эрдэм шинжилгээний нэгжийг Засгийн газрын тогтоолоор байгуулна.

5.3. Үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдалд онцгой ач холбогдол бүхий асуудлаар судалгаа хийх ажлыг Зөвлөл ивээл, хяналтдаа авна. Энэхүү судалгааны ажилтай холбогдсон зохион байгуулалт, төсвийн асуудлыг шийдвэрлэхэд тус дэмжлэг үзүүлнэ.

5.4. Зөвлөлийн хуралдаан, түүний шийдвэр болон үйл ажиллагааг зөвхөн Зөвлөлийн нарийн бичгийн даргын тогтоосон хүрээнд Зөвлөлийн ажлын алба мэдээлнэ.

5.5. Төрийн нууцын зэрэглэлд хамаарах зөвлөлийн баримт бичиг, мэдээ мэдээлэл, биет зүйлсийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар батлагдсан "Монгол Улсын төрийн нууцыг хамгаалах журам"-ын дагуу хадгалж хамгаална.

6. Зөвлөлийн төсөв

6.1. Зөвлөлийн жилийн төсвийн төслийг Зөвлөлийн хуралдаанд танилцуулна.

6.2. Зөвлөл нь үйл ажиллагаа, Ажлын алба, мэдээллийн сан, эрдэм шинжилгээний бие даасан нэгжийг санхүүжүүлэх төсөвтэй байна.

6.3. Зөвлөлийн Ажлын алба болон үйл ажиллагааны төсвийг Засгийн газар тусгай зүйл болгон төсөвлөж Улсын Их Хурлаар батлуулна.

6.4. Зөвлөлийн Ажлын албаны аж ахуй, санхүүгийн хангалтыг Засгийн газрын Төр, засгийн үйлчилгээ аж ахуйг эрхлэх газар хариуцна.



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2003 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр

Дугаар 175

Улаанбаатар хот

"Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 59 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалтыг баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Дашдэлэгийн Улааныг Дорноговь аймгийн шүүхийн шүүгчийн албан тушаалаас огцруулсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.БАГАБАНДИ

Гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдож, шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсон тул

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

2003 оны 7 дугаар сарын 9-ний өдөр

Дугаар 24

Улаанбаатар хот

ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН 175 ДУГААР ЗҮЙЛИЙГ ТАЙЛБАРЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 175 дугаар зүйлийн заалтыг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Монгол Улсын Үндсэн хуулийн тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4, Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.5-д заасныг удирдлага болгон Монгол Улсын Дээд шүүхээс ТОГТООХ нь:

зааснаар тодорхой болзол хангасан, тоон хязгаарлалт, нэмэгдэл татвар тогтоосон, эсхүл эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэйгээр улсын хилээр оруулах, гаргах, дамжин өнгөрүүлэхээр хууль, Улсын Их Хурлын тогтоол, Олон улсын гэрээ, Засгийн газрын шийдвэрт заасан барааг ойлгоно.

Нэг. Эрүүгийн хуулийн 175 дугаар зүйлийг дор дурьдсанаар тайлбарласугай.

3. Хууль бусаар хил нэвтрүүлсэн буюу нэвтрүүлэхийг завдсан, хориглосон буюу хязгаарласан эд зүйлсийн үнийн дүн нь хэрэг үйлдэх үед мөрдөгдөж байсан нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс дээш бол гэмт хэрэгт тооцогдох бөгөөд энэ хэмжээнээс доош бол мөн төрлийн зөрчилд хамаарна.

1. Эрүүгийн хуулийн 175 дугаар зүйлийн 175.1 дэх хэсэгт заасан "*Хориглосон эд зүйл*" гэдэгт Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоол, Олон улсын гэрээ, Засгийн газрын шийдвэрээр улсын хилээр гаргах, оруулах, эсхүл зөвхөн гаргахыг буюу оруулахыг, түүнчлэн дамжин өнгөрүүлэхийг хориглосон бараа, түүхий эд, эд зүйлсийг хамааруулна.

4. Мөн зүйл, хэсэгт заасан "*ховор амьтан*" гэдэгт Амьтны аймгийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь заалтад зааснаар тархац нутагтаа тоо толгой цөөрсөн, нөөц багатай, устаж болзошгүй амьтныг хамааруулан ойлгоно. Ховор амьтанд Засгийн газрын 2001 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 264 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан дараахь хөхтөн амьтан, шувуу, загас хамаарна. Үүнд: аргаль /*ovis ammon*/, янгир /*capra sibirica*/, хунан /*equus hemionus*/, хар сүүлтэй /*gazella subgutturosa*/, халиун бура /*cervus elaphus*/, зэгсний гахай /*sus scrota nigipes*/, говийн шилүүс /*felis lynx gobinsis*/, хадны суусар /*martes foina*/, цоохондой /*felis lybica*/, эрэн хүрнэ /*vormela peregusna*/, ойн бунга /*martes zibellina*/, гоооорой зурам /*citellus alaschanicus*/, алтайн хойлор /*tetraogallus altaicus*/, манхин ганыу /*anser albifrons*/, хээрийн ганыу /*eulabea indica*/, хошуу ганыу /*cygnopsis cygnoides*/, одой ганыу /*anser erythropus*/, хуруут хун /*cygnus olor*/, гунгар хун /*cygnus*

2. Мөн зүйл, хэсэгт заасан "*хязгаарласан эд зүйл*" гэдэгт Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоол, Олон улсын гэрээ, Засгийн газрын шийдвэрээр улсын хилээр нэвтрүүлэхийг тарифын болон тарифын бус аргаар хязгаарласан бараа бүтээгдэхүүн, түүхий эд, эд зүйлс хамаарна.

Тарифын аргаар хязгаарласан гэдэг нь Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоол, Олон улсын гэрээ, Засгийн газрын шийдвэрээр улсын хилээр нэвтрүүлэх тодорхой нэр төрлийн бараанд албан татварын хувь хэмжээг зориудаар онцлон тогтоохыг хэлнэ.

Тарифын бус аргаар хязгаарласан гэдгийг "Гаалийн болон гаалийн тарифын тухай хуулийн зарим зүйл, хэсэг, заалтыг тайлбарлах тухай" Улсын Дээд шүүхийн 2001 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 439 дүгээр тогтоолын 1.3 дахь хэсэгт

bewickii, байгалийн нугас *Anas formosa*, ухаа шумбуур *Aythya baeri*, халзан ангир *Aix galericulata*, ямаан сүүлт *Loxura leucocerphala*, усны бух шувуу *Botaurus stellaris*, цасч дэглий *Egretta alba*, халбаган хошуут *Platalea leucorodia*, дорнын өрөвтас *Ciconia boyciana*, хар өрөвтас *Ciconia nigra*, хонин тоодор *Olis tarda*, азийн цууцан *Limnodromus semipalmatus*, хилэн жигүүрт *Himantopus himantopus*, эгэн хүрэгэнэ *Streptopelia turtur*, цагаан шонхор *Falco rusticolus*, идлэг шонхор, амарын шонхор *Falco amurensis*, цагаан амар *Ctenopharyngodon idella*, давх *Hypophthalmichthys molitrix* зэрэг амьтад хамаарч болно.

5. Мөн зүйл, хэсэгт заасан "валют" гэдэгт Валютын зохицуулалтын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан Монгол Улсын үндэсний валют, гадаад валют, мөнгөжсөн алт зэргийг;

"валютын үнэт зүйл" гэдэгт Валютын зохицуулалтын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасан мөнгөжсөн алттай адилтгах үнэт металл, эрдэнийн чулууг;

"эрдэнэс" гэдэгт Эрдэнэсийн сангийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан түүхий эд, хайлш, химийн нэгдэл, бүтээгдэхүүн, түүх, соёлын дурсгалт зүйл зэрэг ямар ч байдалд байгаа үнэт металл, эрдэнийн чулууг;

"эрдэс" гэдэгт газрын гүнд буюу гадарга дээр физик-химийн процессын явцад бүрэлдэн тогтсон, химийн найрлага, физикийн шинж чанараараа нэг төрөл болох байгалийн биетийг;

"байгалийн төрц" гэдэгт Эрдэнэсийн сангийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасан 400,0 граммаас дээш жинтэй буюу 3,0 x 2,0 сантиметрээс дээш хэмжээтэй, түүнээс бага боловч онцгой чамин дүрс хэлбэртэй байгалийн тогтоц, дүрс хэлбэрээрээ олдсон үнэт металл, эрдэнийн чулууг хамааруулна.

Энэ тайлбарт дурьдсан үнэт металл гэдэгт Засгийн газрын 1997 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 245 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан дараахь үнэт металл: Алт, мөнгө, платина /Платины бүлгийн металлууд: Палладий, иридий, родий, рутений, осмий/-ийг;

Эрдэнийн чулуу гэдэгт доржпалам, маргад, бадмаараг, индраанил, сувд, хувилгаан эрдэнэ,

улбар шар, ногоон, нил ягаан сапфир, эрдэнийн гэрэлт чимид, эрдэнийн жадеит, демантоид, шинель, эрдэнийн опал, усан биндэрьяа, молор, родолит, галтмар, хризолит /перидот/, циркон, биндэрьяа, кунцит, оюу, нил эрдэнэ, пироп /анар/, альмандин /анар/, саран чулуу, хризопраз, шаргал болор, ягаан болор хамаарна. Энэ жагсаалт ангилалд нэр дурьдагдаагүй чулууг ижил төрлийн чулууны адилаар тооцож болно.

6. Эрүүгийн хуулийн 175 дугаар зүйлийн 175.1 дэх хэсэгт заасан "...түүнчлэн их хэмжээ"-ний валют, валютын үнэт зүйл, эрдэнэс, эрдэс" гэдэгт хэрэг үйлдэх үед мөрдөгдөж байсан нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуун хорин таваас хоёр зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх төгрөгийн өртөг бүхий эд зүйл, валют хамаарна. Гадаад валютийг гэмт хэрэг үйлдэх үеийн Монгол банкны албан ёсны ханшийн мэдээг үндэслэн төгрөгт шилжүүлэн тооцно.

Харин мөн зүйлийн 175.1 дэх хэсэгт "...ховор амьтан ... түүнчлэн байгалийн төрцийг" гэж тусгайлан нэрлэж заасан тул эдгээр нэрлэж заасан амьтан, эд зүйлийг хууль бусаар хил нэвтрүүлэх нь тэрхүү эд зүйлийн тоо, хэмжээ, үнийн дүнгээс үл хамааран гэмт хэрэгт тооцогдоно.

7. Мөн зүйлийн 175.1 дэх хэсэгт заасан "улсын хилээр хууль бусаар нэвтрүүлсэн" гэдэгт зохих зөвшөөрөлгүйгээр, гаалийн үзлэгээс гадуур, хилийн боомтгүй газраар, эсхүл гаалийн үзлэгээс нуун далдлах, тухайн эд зүйлийн нэр, төрөл, тоо хэмжээ, хэлбэр дүрс, баглаа боодлыг өөрчлөх, түүнчлэн гаалийн баримт бичиг болон гаалийн лац ломбыг хуурамчар үйлдэх, засварлах, гаалийн мэдүүлэгт бичихгүй орхих буюу худал бичих зэрэг аргаар энэ зүйлд тухайлан заасан эд зүйлсийг улсын хилээр эсвэл Монгол Улсын Гаалийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтын "...гаалийн хяналтын талбайн хил нь тухайн хэсэгтэй гаалийн хилд тооцогдоно" гэсэн заалтад хамаарах гаалийн хяналтын талбайн хилээр гаргасан, оруулсан, дамжин өнгөрүүлсэн үйлдэл /эс үйлдэхүй/ хамаарна.

8. Эрүүгийн хуулийн 175 дугаар зүйлийн 175.2 дахь хэсэгт заасан "түүх соёлын дурсгалт зүйл, музейн үзмэр, эртний амьтан, ургамлын үндэс, үнэт олдвор, археологийн ба палентологийн олдвор, эд өлгийн зүйл" гэдэгт Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 3 дугаар зүйлд заасан эд зүйлсийг хамааруулан ойлгохын



гадна эдгээр эд зүйлсийг хууль бусаар хил нэвтрүүлэх нь тухайн нэрлэсэн зүйлийн тоо, хэмжээ, үнийн дүнгээс үл хамааран гэмт хэрэгт тооцогдоно гэж ойлговол зохино.

9. Мөн зүйл, хэсэгт заасан гэмт хэргийг **"дагтан үйлдсэн"** гэдэгт урьд нь эд зүйлийг хууль бусаар хил нэвтрүүлэх гэмт хэрэг үйлдэж шүүхээр шийтгүүлсэн буюу шийтгүүлээгүйн аль аль нь хамаарах ба гэмт хэрэг үйлдсэн этгээд Монгол Улсын Эрүүгийн хуулийн 72, 73, 76, 78 дугаар зүйлд заасан журмын дагуу эрүүгийн хариуцлага болон ялаас чөлөөлөгдөөгүй байна.

10. Мөн зүйл, хэсэгт заасан **"бүлээлж үйлдсэн"** гэдэг нь хоёр буюу түүнээс дээш этгээд урьдчилан тохиролцсон буюу тохиролцоогүй боловч нэг санаа зорилгоор энэ зүйлд тухайлан заасан эд зүйлийг хууль бусаар хил нэвтрүүлсэн буюу нэвтрүүлэхээр завдсан байхыг хэлнэ.

11. Мөн зүйл, хэсэгт заасан **"албан тушаалынхаа байдлыг ашиглаж үйлдсэн"** гэдэгт албан тушаалтан өөрт олгогдсон албаны бүрэн эрх, зохих хууль тогтоомжийн дагуу гаалийн үзлэг шалгалтаас чөлөөлөгдсөн байдал, түүнчлэн гаалийн үзлэг шалгалт хийх, түүнд хяналт тавих, зохион байгуулах, улсын хилээр бараа бүтээгдэхүүн, түүхий эд гаргах, оруулах зэрэг албан тушаалынхаа байдлыг ашиглаж энэ зүйлд заасан эд зүйлийг хууль бусаар хил нэвтрүүлсэн, эсхүл ийм үйлдэлд туслалцаа үзүүлсэн байхыг ойлгоно.

Албан тушаалтны ийм гэмт үйлдэл, эс үйлдэхгүйг Эрүүгийн хуулийн хорин наймдугаар бүлгийн албан тушаалын гэмт хэргээр давхар зүйлчлэх шаардлагагүй гэж ойлгох нь зүйтэй.

12. Мөн зүйлийн 175.3 дахь хэсэгт заасан **"онц аюултай гэмт хэрэгтэн"** гэдэг нь гэмт этгээд Эрүүгийн хуулийн Ерөнхий ангийн 24 дүгээр зүйлд заасны дагуу шүүхийн шийтгэх тогтоолоор онц аюултай гэмт хэрэгтнээр нэгэнт тооцогдсон этгээд эд зүйлийг хууль бусаар хил нэвтрүүлэх гэмт хэрэг үйлдсэн байхыг хэлнэ.

13. Мөн зүйлийн 175.3 дахь хэсэгт заасан **"зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл"** гэдгийг Монгол Улсын Дээд шүүхийн 2003 оны 5 дугаар сарын 05-ны өдрийн 10 дугаар тогтоолд тайлбарласнаар ойлгож хэрэглэнэ.

14. Эрүүгийн хуулийн 175 дугаар зүйлийн 175.3 дахь хэсэгт заасан эд зүйлийг хууль бусаар хил нэвтрүүлэх гэмт хэргийг **"онц их хэмжээтэй үйлдсэн"** гэдэгт хэрэг үйлдэх үед мөрдөгдөж байсан нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуугаас дээш дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх төгрөгийн өртөг бүхий энэ зүйлд дурьдсан эд зүйлийг хууль бусаар хил нэвтрүүлсэн байхыг ойлгоно.

15. Эрүүгийн хуулийн 175 дугаар зүйлд заасан гэмт хэрэг үйлдэж олсон эд зүйл буюу түүний үнэ, гэмт хэрэг үйлдэхдээ хэрэглэсэн зэвсэг, хэрэгсэл, гэмт үйлдлийн замаар олсон орлого, түүнтэй адилтган үзэх бусад эд зүйлийг Эрүүгийн хуулийн Ерөнхий ангийн 49 дүгээр зүйлийн 49.2 дахь хэсгийн заалт болон Гаалийн тухай хуулийн зохих зүйл, заалтын дагуу заавал хурааж улсын орлого болговол зохино.

16. Мөн зүйлийн 175.3 дахь хэсэгт заасан гэмт хэрэг үйлдсэн этгээдэд "эд хөрөнгийг хураах ял" заавал хэрэглэхийг заасууяй.

Хоёр. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Эрүүгийн хуулийн 74, 172' дүгээр зүйлийг нэг мөр ойлгон зөв хэрэглэх тухай" Улсын Дээд шүүхийн Бүгд хурлын 1994 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 180 дугаар тогтоолын энэ тогтоолоор тайлбарласанд хамаарах заалтуудыг хүчингүй болсонд тооцсууяй.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ	Ч.ГАНБАТ
ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ТАНХИМЫН ТЭРГҮҮН	Н.ТӨРБАТ

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл.

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.

Улаанбаатар-12
Төрийн ордон

☎ 329612
Индекс 14003

☎ 329487
Хэвлэлийн хуудас 2.5